

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

П.Н.ШАСТИНЫ НЭРЭМЖИТ УЛСЫН ГУРАВДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН 2025 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: САГ-2026/314/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: В.Эрдэнэцогт Утас: 260512 Цахим хаяг: erdenetsogt@audit.gov.mn Ахлах аудитор: М.Пагамдулам Утас: 261628 Цахим хаяг: pagamdulam@audit.gov.mn Өлзийт экаунт аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал: Ч.Эрдэнэжав Утас: 70130460 Цахим хаяг: auditulziit@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
3.5.1 Төсвийн төлөвлөлт	16
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	17
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	19
4. АУДИТЫН ТАЙЛАН	20
4.1 Ерөнхий зүйл	20
4.2 Материаллаг байдал	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	20
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	21
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	21
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	21
4.5.1 Завсрын аудитын талаар	21
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	21
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	22
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	23
5.1 Төлбөрийн акт	24
5.2 Албан шаардлага	24
5.3 Зөвлөмж	24
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	26

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БҮТЭЗүйлс	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин
УИХ	Улсын их хурал
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/366
танай _____-ны № _____-т

П.Н.ШАСТИНЫ НЭРЭМЖИТ УЛСЫН
ГУРАВДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН
ЗАХИРАЛ Ц.ТӨМӨР-ОЧИР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын гуравдугаар төв эмнэлгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус эмнэлгийн эмч мэргэжилтнүүд гадаадын 29 эрдэмтэн профессоруудтай хамтран гадаад улсад эмчлүүлэх зайлшгүй шаардлагатай 120 иргэнд өндөр өртөгтэй, дэлхийн стандартад нийцсэн, нийт 2,000,000.0 мянган төгрөгийн мэс заслыг амжилттай хийсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Улсын гуравдугаар төв эмнэлэг нь мэдрэлийн мэс засал хийхэд нэн шаардлагатай тоног төхөөрөмжийг 1,194,677.6 мянган төгрөгөөр бэлтгэж, тархи нугасны 1908 нээлттэй мэс заслыг хийж, мэдрэлийн мэс заслын 5 шинэ технологийг Монголд амжилттай нутагшуулсан байна.

Бусад асуудал

Тус эмнэлгийн удирдлага, хамт олны үйл ажиллагааны үр дүнд МОН/008, МОН/009 төслийг амжилттай эхлүүлэн Зүрх судасны үндэсний төвийг барьж байгуулах асуудлыг Улсын Их Хурлын байнгын хороогоор хэлэлцүүлэн батлуулж, Монгол Улсын Засгийн газар, Европын Сэргээн босголт банк хооронд нэн хөнгөлөлттэй 34.9 сая ам. долларын зээлийн гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	29,178,885,108.64	14,213,033,224.96
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	3,535,543,228.60	1,372,228,809.34
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	3,535,543,228.60	1,372,228,809.34
31210	Төгрөг	3,535,543,228.60	1,372,228,809.34
31211	Төрийн сан харилцах	3,535,543,228.60	1,372,228,809.34
33	АВЛАГА	17,160,454,920.20	2,975,129,677.10
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	17,151,784,920.20	2,975,129,677.10
33500	Бусад авлага	8,670,000.00	-
33510	Байгууллагаас авах авлага	8,670,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	8,482,886,959.84	9,865,674,738.52
35100	Түүхий эд материал	1,332,251,619.61	1,755,844,430.40
35130	Эм боох материал	1,332,251,619.61	1,755,844,430.40
35400	Хангамжийн материал	7,150,635,340.23	8,109,830,308.12
35410	Бичиг хэргийн материал	377,500.00	414,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	4,813,500.00	13,219,680.00
35440	Түлш, шатах тослох материал	2,613,710.00	4,553,045.28
35470	Бусад хангамжийн материал	7,142,830,630.23	8,091,643,582.84
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	51,780,765,994.26	60,439,430,596.58
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	51,780,765,994.26	60,439,430,596.58
39200	Биет хөрөнгө	49,797,654,440.83	57,940,816,552.42
39201	Барилга, байгууламж, орон сууц	34,249,359,185.60	34,996,134,186.40
39202	Хуримтлагдсан элэгдэл	(4,524,315,369.74)	(5,183,902,121.87)
39203	Авто- тээврийн хэрэгсэл	1,062,591,567.80	2,712,596,526.80
39204	Хуримтлагдсан элэгдэл	(364,799,808.11)	(277,072,008.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	63,112,192,847.35	50,949,229,491.52
39206	Хуримтлагдсан элэгдэл	(44,499,757,470.70)	(26,465,860,080.02)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	2,684,662,153.56	2,216,771,699.83
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,922,278,664.93)	(1,007,081,142.24)
39300	Биет бус хөрөнгө	1,983,111,553.43	2,498,614,044.16
39301	Программ хангамж	512,018,719.00	1,088,609,531.50
39302	Хуримтлагдсан элэгдэл	(393,638,985.57)	(454,727,307.34)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,864,731,820.00	1,864,731,820.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	80,959,651,102.90	74,652,463,821.54
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	15,874,291,243.68	2,901,623,010.77
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15,874,291,243.68	2,901,623,010.77
41300	Өглөг	15,811,088,243.68	2,818,561,195.77
41360	Бусад өглөг	15,811,088,243.68	2,818,561,195.77
41361	Байгууллагад төлөх өглөг	15,799,829,543.68	2,818,561,195.77
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	11,258,700.00	-
41400	Урьдчилж орсон орлого	63,203,000.00	83,061,815.00
41440	Бусад урьдчилж орсон орлого	63,203,000.00	83,061,815.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	65,085,359,859.22	71,750,840,810.77
51	Засгийн газрын хувь оролцоо	65,085,359,859.22	71,750,840,810.77
51100	Засгийн газрын оруулсан капитал	17,104,644,437.50	17,104,644,437.50
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	17,104,644,437.50	17,104,644,437.50
51200	Хуримтлагдсан үр дүн	26,919,161,984.69	33,586,445,048.44
51210	Өмнөх үеийн үр дүн	33,624,336,611.63	26,920,964,096.89

П.Н.Шастины Улсын гуравдугаар төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

51220	Тайлант үеийн үр дүн	(6,705,174,626.94)	6,665,480,951.55
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	21,061,553,437.03	21,059,751,324.83
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	80,959,651,102.90	74,652,463,821.54

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	82,945,610,158.97	95,605,452,359.56
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,165,253,514.97	95,605,452,359.56
120	Нийтлэг татварын бус орлого	9,165,253,514.97	22,740,406,094.56
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,757,578,047.42	8,052,280,259.15
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,329,245,146.01	4,819,049,270.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,428,332,901.41	3,233,230,989.15
120005	Түрээсийн орлого	168,370,440.00	235,634,640.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,695,983,984.80	13,584,346,601.48
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	543,321,042.75	868,144,593.93
122	Тусламжийн орлого	-	72,865,046,265.00
1221	Хандив тусламж / дотоод/	-	72,865,046,265.00
12215	Төсөв хоорондын хандив, тусламж	-	72,865,046,265.00
122151	Улсын эмнэлгүүдэд ЭМДС- с олгох шилжүүлгийн орлого	-	72,865,046,265.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	73,780,356,644.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	73,780,356,644.00	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	73,780,356,644.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	89,206,816,654.80	88,935,842,706.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	89,206,816,654.80	88,935,842,706.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	88,246,342,889.80	88,129,588,231.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	28,276,351,095.32	29,661,089,354.40
210101	Үндсэн цалин	15,187,821,772.01	16,376,410,381.25
210102	Нэмэгдэл	9,253,489,162.31	9,242,350,055.44
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,684,146,000.00	1,704,698,687.71
210104	Урамшуулал	2,150,894,161.00	2,337,630,230.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,677,651,109.87	3,856,391,721.95
210201	Тэтгэврийн даатгалын зардал	2,482,957,538.32	2,590,271,936.62
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	291,668,836.53	303,206,308.61
210203	ҮОМШӨ- ний даатгалын зардал	224,553,811.79	256,144,542.55
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	135,349,566.97	141,063,501.94
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	543,121,356.26	565,705,432.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,349,880,657.72	1,378,547,249.93
210301	Гэрэл, цахилгаан	713,982,916.14	938,674,286.66
210302	Түлш, халаалт	283,152,782.41	218,465,578.94

П.Н.Шастины Улсын гуравдугаар төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

210303	Цэвэр, бохир ус	352,744,959.17	221,407,384.33
2104	Хангамж, бараа материалын зардал	652,307,158.87	588,653,819.88
210401	Бичиг хэрэг	79,666,957.41	63,957,387.00
210402	Тээвэр, шатахуун	39,602,141.46	47,904,975.77
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	27,905,237.39	30,772,522.72
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	122,946,160.00	124,508,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	132,703,738.00	159,885,293.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	249,482,924.61	161,625,141.39
2105	Нормативт зардал	44,899,051,528.50	40,637,710,935.41
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	43,361,589,408.50	39,306,910,675.41
210502	Хоол, хүнс	1,458,690,070.00	1,304,583,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	78,772,050.00	26,217,260.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,891,798,618.50	1,746,156,594.84
210601	Багаж, техник, хэрэгсэл	79,466,718.00	104,088,709.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	76,059,780.00	110,700,460.00
210604	Урсгал засвар	1,736,272,120.50	1,531,367,425.84
2107	Томилолт, зочны зардал	304,056,003.60	54,306,990.00
210702	Дотоод албан томилолт	304,056,003.60	54,306,990.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	673,085,999.24	3,012,454,410.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	613,723,314.26	2,959,048,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	16,500,000.00	16,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	784,384.00	833,976.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	862,968.00	3,514,388.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	200,178.00	412,000.00
210807	Газрын төлбөр	11,460,211.00	11,460,211.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4,098,600.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	25,456,343.98	20,685,835.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,522,160,718.18	7,194,277,154.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	106,981,300.00	102,916,184.44
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6,415,179,418.18	7,091,360,970.55
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	960,473,765.00	806,254,475.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	960,473,765.00	806,254,475.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	872,395,065.00	717,084,475.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	88,078,700.00	89,170,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)- (II)	(6,261,206,495.83)	6,669,609,653.16
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	443,968,131.11	4,128,701.61
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	-	4,128,701.61
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	443,968,131.11	-
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)- (V)	(443,968,131.11)	(4,128,701.61)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	(6,705,174,626.94)	6,665,480,951.55

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	83,411,348,356.22	95,358,145,222.25
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,910,627,087.42	95,358,145,222.25
120	Нийтлэг татварын бус орлого	6,910,627,087.42	8,316,443,714.15
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,910,627,087.42	8,316,443,714.15
120004	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,322,593,746.01	4,838,908,085.00
120004	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,588,033,341.41	3,477,535,629.15
122	Тусламжийн орлого	-	87,041,701,508.10
1221	Хандив тусламж /дотоод/	-	87,041,701,508.10
12215	Төсөв хоорондын хандив, тусламж	-	87,041,701,508.10
122151	Улсын эмнэлгүүдэд ЭМДС-с олгох шилжүүлгийн орлого	-	87,041,701,508.10
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	76,500,721,268.80	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	76,500,721,268.80	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	76,500,721,268.80	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	77,782,397,761.47	95,351,651,968.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	77,782,397,761.47	95,351,651,968.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	76,790,762,696.47	94,534,138,793.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	28,276,351,095.32	29,661,089,354.40
210101	Үндсэн цалин	15,196,007,280.68	16,376,410,381.25
210102	Нэмэгдэл	9,246,452,807.53	9,242,350,055.44
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,682,996,846.11	1,704,698,687.71
210104	Урамшуулал	2,150,894,161.00	2,337,630,230.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,677,651,109.87	3,856,391,721.95
210201	Тэтгэврийн даатгалын зардал	2,595,856,126.64	2,590,271,936.62
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	268,446,621.51	303,206,308.61
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	167,942,837.42	256,144,542.55
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	128,932,416.40	141,063,501.94
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	516,473,107.90	565,705,432.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,368,493,522.29	1,378,547,249.93
210301	Гэрэл, цахилгаан	713,982,916.14	938,674,286.66
210302	Түлш, халаалт	301,765,646.98	218,465,578.94
210303	Цэвэр, бохир ус	352,744,959.17	221,407,384.33
2104	Хангамж, бараа материалын зардал	409,113,537.39	457,910,686.72
210401	Бичиг хэрэг	68,087,743.00	64,921,187.00
210402	Тээвэр, шатахуун	38,737,750.00	48,353,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	27,905,237.39	30,772,532.72
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	135,732,300.00	124,508,500.00

П.Н.Шастины Улсын гуравдугаар төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	138,650,507.00	189,354,877.00
2105	Нормативт зардал	40,087,598,835.71	52,891,962,324.15
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	38,365,333,985.71	51,389,145,144.15
210502	Хоол, хүнс	1,547,835,900.00	1,367,261,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	174,428,950.00	135,556,080.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,743,055,600.91	2,802,589,687.66
210601	Багаж, техник, хэрэгсэл	162,900,501.41	630,263,151.50
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	84,987,320.00	110,700,460.00
210604	Урсгал засвар	1,495,167,779.50	2,061,626,076.16
2107	Томилолт, зочны зардал	305,340,010.00	54,306,990.00
210702	Дотоод албан томилолт	305,340,010.00	54,306,990.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	818,826,684.98	3,323,274,594.26
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	759,921,200.00	3,269,831,684.26
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	16,500,000.00	16,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	784,384.00	833,976.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	862,968.00	3,514,388.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	200,178.00	412,000.00
210807	Газрын төлбөр	11,460,211.00	11,460,211.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4,098,600.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	24,999,143.98	20,722,335.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	104,332,300.00	108,066,184.44
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	104,332,300.00	108,066,184.44
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	991,635,065.00	817,513,175.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	991,635,065.00	817,513,175.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	872,395,065.00	717,084,475.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	119,240,000.00	100,428,700.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	5,628,950,594.75	6,493,253.74
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	2,127,765,688.18	2,169,807,673.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,127,765,688.18	2,169,807,673.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,127,765,688.18	2,169,807,673.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,127,765,688.18	2,169,807,673.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(2,127,765,688.18)	(2,169,807,673.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	3,501,184,906.57	(2,163,314,419.26)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	34,358,322.03	3,535,543,228.60
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,535,543,228.60	1,372,228,809.34

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 01-р сарын 1-нээрх үлдэгдэл	17,104,644,437.50	21,061,553,437.03	33,624,336,611.63	71,790,534,486.16
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	17,104,644,437.50	21,061,553,437.03	33,624,336,611.63	71,790,534,486.16
Тайлант үеийн үр дүн/ Цэвэр ашиг алдагдал/	-	-	(6,05,174,626.94)	(6,705,174,626.94)
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	17,104,644,437.50	21,061,553,437.03	26,919,161,984.69	65,085,359,859.22
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	1,802,112.20	1,802,112.20
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	17,104,644,437.50	21,061,553,437.03	26,920,964,096.89	65,087,161,971.42
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(1,802,112.20)	-	(1,802,112.20)
Тайлант үеийн үр дүн/ Цэвэр ашиг алдагдал/	-	-	6,665,480,951.55	6,665,480,951.55
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	17,104,644,437.50	21,059,751,324.83	33,586,445,048.44	71,750,840,810.77

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖ ИЙН ДҮН	95,181,752,900.00	95,358,145,222.25	(176,392,322.25)	100.2
12	Татварын бус орлого	95,181,752,900.00	95,358,145,222.25	(176,392,322.25)	100.2
120	Нийтлэг татварын бус орлого	8,854,979,700.00	8,316,443,714.15	538,535,985.85	93.9
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	4,949,124,500.00	4,838,908,085.00	110,216,415.00	97.8
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	3,905,855,200.00	3,477,535,629.15	428,319,570.85	89.0
122	Тусламжийн орлого	86,326,773,200.00	87,041,701,508.10	(714,928,308.10)	100.8
122001	Хандив тусламж /дотоод/	86,326,773,200.00	87,041,701,508.10	(714,928,308.10)	100.8
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	98,733,614,000.00	97,521,459,641.51	1,212,154,358.49	98.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	98,733,614,000.00	97,521,459,641.51	1,212,154,358.49	98.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ НИЙ ЗАРДАЛ	97,803,874,300.00	96,703,946,466.51	1,099,927,833.49	98.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	29,840,652,800.00	29,661,089,354.40	179,563,445.60	99.4
210101	Үндсэн цалин	16,200,307,600.00	16,376,410,381.25	(176,102,781.25)	101.1
210102	Нэмэгдэл	9,358,711,400.00	9,242,350,055.44	116,361,344.56	98.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,944,000,000.00	1,704,698,687.71	239,301,312.29	87.7
210104	Урамшуулал	2,337,633,800.00	2,337,630,230.00	3,570.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,880,613,600.00	3,856,391,721.95	24,221,878.05	99.4
210201	Тэтгэврийн даатгал	2,645,077,000.00	2,590,271,936.62	54,805,063.38	97.9
210202	Тэтгэмжийн даатгал	308,884,200.00	303,206,308.61	5,677,891.39	98.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	68,184,800.00	256,144,542.55	(187,959,742.55)	375.7
210204	Ажилгүйдлийн даатгал	240,699,300.00	141,063,501.94	99,635,798.06	58.6
210205	Эрүүл мэндийн даатгал	617,768,300.00	565,705,432.23	52,062,867.77	91.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,379,011,500.00	1,378,547,249.93	464,250.07	100.0
210301	Гэрэл, цахилгаан	808,341,100.00	938,674,286.66	(130,333,186.66)	116.1
210302	Түлш, халаалт	303,806,400.00	218,465,578.94	85,340,821.06	71.9
210303	Цэвэр, бохир ус	266,864,000.00	221,407,384.33	45,456,615.67	83.0
2104	Хангамж, бараа материалын зардал	518,026,600.00	457,910,686.72	60,115,913.28	88.4
210401	Бичиг хэрэг	77,180,000.00	64,921,187.00	12,258,813.00	84.1
210402	Тээвэр, шатахуун	56,886,600.00	48,353,600.00	8,533,000.00	85.0
210403	Шуудан, холбоо интернэтийн төлбөр	40,000,000.00	30,772,522.72	9,227,477.28	76.9

П.Н.Шастины Улсын гуравдугаар төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчд ийн устгал, ариутгал	138,000,000.00	124,508,500.00	13,491,500.00	90.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	205,960,000.00	189,354,877.00	16,605,123.00	91.9
2105	Нормативт зардал	52,897,380,300.00	52,891,962,324.15	5,417,975.85	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	51,389,145,200.00	51,389,145,144.15	55.85	100.0
210502	Хоол, хүнс	1,372,678,100.00	1,367,261,100.00	5,417,000.00	99.6
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	135,557,000.00	135,556,080.00	920.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,788,119,100.00	4,972,397,360.66	815,721,739.34	85.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,425,114,700.00	2,075,468,711.50	349,645,988.50	85.6
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	117,000,000.00	110,700,460.00	6,299,540.00	94.6
210604	Урсгал засвар	3,246,004,400.00	2,786,228,189.16	459,776,210.84	85.8
2107	Томилолт, зочны зардал	54,776,000.00	54,306,990.00	469,010.00	99.1
210702	Дотоод албан томилолт	54,776,000.00	54,306,990.00	469,010.00	99.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ ний төлбөр, хураамж	3,337,214,600.00	3,323,274,594.26	13,940,005.74	99.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ ний төлбөр хураамж	3,269,831,700.00	3,269,831,684.26	15.74	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	16,500,000.00	16,500,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	5,200,000.00	833,976.00	4,366,024.00	16.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3,745,200.00	3,514,388.00	230,812.00	93.8
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	412,000.00	412,000.00	-	100.0
210807	Газрын төлбөр	11,460,300.00	11,460,211.00	89.00	100.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4,098,600.00	-	4,098,600.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	25,966,800.00	20,722,335.00	5,244,465.00	79.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	108,079,800.00	108,066,184.44	13,615.56	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	108,079,800.00	108,066,184.44	13,615.56	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	929,739,700.00	817,513,175.00	112,226,525.00	87.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	929,739,700.00	817,513,175.00	112,226,525.00	87.9

П.Н.Шастины Улсын гуравдугаар төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	829,311,000.00	717,084,475.00	112,226,525.00	86.5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,428,700.00	100,428,700.00	-	100.0
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(3,551,861,100.00)	(2,163,314,419.26)	(1,388,546,680.74)	60.9
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛ ЭХ ЭХ ҮҮСВЭР	3,551,861,100.00	2,163,314,419.26	1,388,546,680.74	60.9
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	3,551,861,100.00	2,163,314,419.26	1,388,546,680.74	60.9
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	3,535,543,228.60	(3,535,543,228.60)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,372,228,809.34	(1,372,228,809.34)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1,583	-	1,583.00	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	778	778	-	100.0
620001	Удирдах ажилтан	8	8	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	760	760	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	10	10	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улсын гуравдугаар төв эмнэлэг нь эрхэм зорилгоо “Үйлчлүүлэгч төвтэй, дээд зэргийн чанартай тусламжийг үзүүлэгч Үндэсний тэргүүлэгч эмнэлэг” байна гэж тодорхойлж эмнэлгийн бүх түвшний үйлчилгээнд “Чанарын дэвшлийг хангах жил” болгон зарлаж эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн бодлогын хүрээнд тусламж үйлчилгээний чанарт анхааран ажиллахаар зорилтоо тодорхойлсон байна.

Дээрх зорилтын хүрээнд үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

- Зүрхний судас, зүрхний шигдээс, зүрхний үйл оношилгоо, зүрхний хэм судлалын тусламж, үйлчилгээ үзүүлэх;
- Мэдрэл судлал, мэдрэлийн үйл оношилгоо, тархины харвалтын үеийн тусламж, үйлчилгээг үзүүлэх;
- Зүрх, судасны мэс заслын тусламж үйлчилгээ үзүүлэх;
- Тархи, нуруу нугас, мэдрэлийн мэс заслын тусламж, үйлчилгээ;
- Судсанд дотуурх оношилгоо, эмчилгээний тусламж, үйлчилгээ;
- Уушги, амьсгалын эрхтний эмгэгийн тусламж, үйлчилгээ;
- Тархины харвалт, зүрхний шигдээсний эрт үеийн сэргээн засах үйлчилгээ үзүүлэх;
- Дүрс оношилгооны тусламж, үйлчилгээ үзүүлэх;
- Гематологи, биохимийн лабораторийн үйлчилгээ үзүүлэх;
- Эмнэлзүйн, эмнэлгийн үйл ажиллагааны бусад чиглэлд тусламж үйлчилгээ үзүүлэх;

Тайлант онд тус эмнэлгийн эмч мэргэжилтнүүд нь зүрх судасны хүнд хэлбэрийн нарийсал, бага насны хүүхэд болон насанд хүрэгсдийн хүнд, хавсарсан хэлбэрийн төрөлхийн болон олдмол гажууд зэрэг 15 чиглэлийн өндөр өртөгтэй мэс заслыг 7661 иргэнд үзүүлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус эмнэлэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээний худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт өөрчлөлт;
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 04 дүгээр тогтоолоор “Жагсаалт төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам”-г “шинэчлэн баталсан;
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам” шинэчлэн баталсан;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улсын гуравдугаар төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус эмнэлгийн захирлын 2020 оны А/173 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрдөж, 2025 оны А/245 тоот тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улсын гуравдугаар төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,307,187.2 мянган төгрөгөөр буюу 7.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,535,543.3	1,372,228.8	(2,163,314.5)
Авлага	17,160,454.9	2,975,129.7	(14,185,325.2)
Бараа материал	8,482,886.9	9,865,674.8	1,382,787.9
Үндсэн хөрөнгө	51,780,766.0	60,439,430.6	8,658,664.6
Нийт хөрөнгө	80,959,651.1	74,652,463.9	(6,307,187.2)
Өр төлбөр	15,874,291.2	2,901,623.1	(12,972,668.1)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	65,085,359.9	71,750,840.8	6,665,480.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	80,959,651.1	74,652,463.9	(6,307,187.2)

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 1,372,228.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,163,314.5 мянган төгрөгөөр буурсан нь эм, эмнэлгийн хэрэгслийн өр төлбөрийг оны эцэст төлсөн нь голлон нөлөөлсөн.

Авлагын дансны үлдэгдэл 2,975,129.7 мянган төгрөг болж өмнөх оноос 14,185,325.2 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны эмнэлгийн тусламж үйлчилгээний эрүүл мэндийн даатгалын сангаас авах 17,160,454.9 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан нь голлон нөлөөлсөн.

Бараа материалын дансны үлдэгдэл 9,865,674.8 мянган төгрөг болж өмнөх оноос 1,382,787.9 мянган төгрөгөөр өсөхөд худалдан авсан 40,897,138.5 мянган төгрөг, хандиваар авсан 868,144.6 мянган төгрөг, нийт 41,765,283.1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсан 40,382,495.3 мянган төгрөгөөр, хасагдсан нь нөлөөлсөн.

Үндсэн хөрөнгө данс төсвийн хөрөнгөөр худалдан авсан 2,169,807.7 мянган төгрөг, Эрүүл мэндийн сайдын 2025 оны 107 дугаар тушаалаар 1,243,500.0 мянган төгрөг, 234 дүгээр тушаалаар 36,256.0 мянган төгрөг, 355 дугаар тушаалаар 19,506.9 мянган төгрөг, 482 дугаар тушаалаар 26,393.4 мянган төгрөг, 514 дүгээр тушаалаар 2,718,584.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, мөн аж ахуйн нэгж байгууллагаас хандив тусламжаар 977,908.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг тус тус үнэ төлбөргүй хүлээн авч, ТӨБЗГ-ын 2025 оны 822 дугаар тушаалаар Монгол улс дахь зүрх судлал, зүрхний мэс засал ба телемедицин төслөөс 3,232,156.0 мянган төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авсан, 805 дугаар тушаалаар 5,330,041.7 мянган төгрөгийн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоосноор тус тус нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2025 оны 764 дүгээр тушаалаар 4,128.8 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг балансаас балансад шилжүүлэн, элэгдлийн зардал 7,091,360.9 мянган төгрөгөөр тус тус хасагдсан.

Өр төлбөр дансны үлдэгдэл 2,901,623.1 мянган төгрөг болж өмнөх оноос 12,972,668.1 мянган төгрөгөөр буурсан нь бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудад өгөх эм, эмнэлгийн хэрэгслийн өр төлбөрийг төлж барагдуулсантай холбоотой байна.

Программ хангамжийн талаарх судалгааны үр дүн:

Тус байгууллага нь нийт 18 ширхэг 1,088,609.5 мянган төгрөгийн программ хангамжийг үйл ажиллагаандаа ашигладаг бөгөөд тайлант онд 108,268.5 мянган төгрөгийн лиценз, хөгжүүлэлтийн төлбөр төлсөн байна. Тухайлбал: Эмнэл зүйн үйл ажиллагаанд ашигладаг E-health программын хөгжүүлэлтийн төлбөрт 72,000.0 мянган төгрөг, эмнэлгийн ERP системийн ашиглалт, үйлчилгээний төлбөрт 32,400.0 мянган төгрөгийг тус тус төлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус эмнэлгийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих орлогыг 82,667,896.9 мянган төгрөг, үйл

ажиллагааны орлогоос 13,035,630.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлэхээр, нийт зардлыг 95,703,527.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлсний зардлыг 765,355.1 мянган төгрөг, ажил олгогчоос олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлд төлөх зардлыг 32,576.0 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 320,000.0 мянган төгрөг, эд хогшил худалдан авах зардлыг 881,549.0 мянган төгрөг, урсгал шилжүүлгийн зардлыг 46,398.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 43,059.0 мянган төгрөгөөр тус тус бууруулж, норматив зардлыг 2,612,556.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 2,505,848.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, нийт зардлыг 98,733,614.1 мянган төгрөгөөр баталжээ.

Тус эмнэлэг нь төсвийн төслөө тайлант оны эхэнд Удирдах зөвлөлөөр батлуулан, боловсруулсан боловч эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын бүрдүүлэлт, Эрүүл мэндийн сайдын цаг үеийн тушаал шийдвэрээс шалтгаалан төлөвлөгөө, гүйцэтгэлийн уялдаа алдагдахад хүрсэн байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 521,774.1 мянган төгрөгөөр бууруулж нийт 3 удаа тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 86,326,773.2 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 8,854,979.7 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 3,551,861.1 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс бүрдүүлэхээр байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний санхүүжилтээс 87,041,701.5 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 4,838,908.1 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 3,477,535.6 мянган төгрөг, нийт 95,358,145.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 97,521,459.6 мянган төгрөг буюу 98.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 101,487.3 мянган төгрөг, дээд шатны төсвөөс хуваарилсан зардлыг 1,110,667.1 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/						
д/д	Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71602	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	98,733,614.0	97,521,459.6	1,212,154.4	98.8
2	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	76,379,163.5	76,277,676.2	101,487.3	99.9
3	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, шагнал урамшуулал	89,170.0	89,170.0	-	100.0
4	83603	Нэмэлт-Дээд шатны төсвөөс хуваарилсан	22,265,280.5	21,154,613.4	1,110,667.1	95.0

Байгууллагуудын орон тооны цомхотголын талаар;

Тус байгууллагын орон тоог 790 байхаар баталж, 30,606,007.9 мянган төгрөгийн цалингийн зардлыг төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр орон тоог эмнэлгийн захирлын 2025 оны 126 дугаар тушаалаар 770 байхаар баталж, 105,660.0 мянган төгрөгийн цалингийн зардлыг хэмнэж, эмч, эмнэлгийн ажилчдаас бусад орон тоог 9.0 хувиар бууруулсан байна.

Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын талаар;

Эмнэлгийн даргын 2024 оны А/07 дугаар “Хоол унааны нөхөх зардлыг тогтоох тухай” тушаалаар нэг өдрийн хоолны зардлыг 10.0 мянган төгрөгөөр тооцон унаа хоолны мөнгийг олгодог бөгөөд 1,944,000.0 мянган төгрөгийн унаа хоолны зардал төлөвлөж, гүйцэтгэлээр 1,704,698.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний судалгааны талаар;

Улсын гуравдугаар төв эмнэлэг нь тайлант онд сургалтын 3 арга хэмжээний зардалд 8,382.0 мянган төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 7,772.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Тухайлбал: Резидент эмч нарын төгсөлтийн дараах чиглүүлэх сургалтыг 2 удаа зохион байгуулан 4,872.0 мянган төгрөг, эрүүл мэндийн салбарын тэргүүлэх чиглэл батлах эрдэм шинжилгээний хуралд 3,510.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3.1 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Люксембургийн Их гүнт Улсын буцалтгүй тусламжаар Монгол улс дахь зүрх судлал, зүрхний мэс засал ба телемедицин МОН/007 төслийг хэрэгжүүлэн, төсөл арга хэмжээнд зориулж 17,443,458.6 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр төсөл арга хэмжээ нь 62 хувьтай бөгөөд нийт 10,677,936.7 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилт ийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	Монгол улс дахь зүрх судлал, зүрхний мэс засал ба телемедицин МОН/007 төсөл	2022-2027	1. Зүрх судасны өвчнөөс урьдчилан сэргийлэх үндэсний хэмжээний үйл ажиллагааны төлөвлөгөө нь төслийн өвөрмөц үйл ажиллагаагаар дэмжигдэх 2. Зүрх судасны үндэсний төвийн зүрх судасны мэс засал болон зүрх судасны цогц тусламж үйлчилгээ улам чадавхжих” 3. Зүрх судасны тусламж үйлчилгээ эрүүл мэндийн тусламжийн пирамид/шатлалын бүх түвшинд бэхжих 4. Зүрх судасны үндэсний төвийг чадавхжуулах, институтчилэх	62.0	17,443,458.6	10,677,936.7

Монгол улс дахь зүрх судлал, зүрхний мэс засал ба телемедицин МОН/007 төсөл нь 2027 оны 10 сард хэрэгжиж дуусах бөгөөд, МОН/008, МОН/009 төсөл үргэлжлүүлэн хэрэгжихээр гэрээ хийгдсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Улсын Гуравдугаар төв эмнэлэг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 51,135,837.9 мянган төгрөгийг бараа ажил, үйлчилгээ худалдан авахаар баталсан бөгөөд гүйцэтгэлээр Төрийн худалдан авах ажиллагааны газарт эрх шилжүүлэн 39,326,543.2 мянган төгрөг, нээлттэй тендер сонгон шалгаруулалтын аргаар 2,371,908.0 мянган төгрөг, харьцуулалтын аргаар 422,086.0 мянган төгрөг, ерөнхий гэрээний аргаар цахим дэлгүүрээс 8,285,300.7 мянган төгрөг, шууд худалдан авалтаар 730,000.0 мянган төгрөгийн хөрөнгө бараа материал тус тус худалдан авч, нийт 89 аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулж 47,919,157.6 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улсын гуравдугаар төв эмнэлгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах дотоод хяналт шалгалт, эрүүл мэндийн санхүүжилтийн орлого, түрээсийн орлого, худалдан авах ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Өлзийт экаунт аудит ХХК-ийн ахлах аудитор Ч.Эрдэнэжав, аудитор Б.Төрмөнх нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг Ц.Бямбажав, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор М.Пагамдулам, аудитын менежер В.Эрдэнэцогт, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Улсын гуравдугаар төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/62 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 89,206,816.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 892,068.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор эмнэлгийн захирал 2024 оны А/110 дугаар “хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, үйл ажиллагааны гүйцэтгэлийн сахилга, хариуцлагыг бүх түвшинд өндөржүүлэн төсвийн хэмнэлтийн зарчмыг мөрдөн ажиллах” тушаал гарган үйл ажиллагаандаа мөрдөж, зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласнаар тайланд онд хангамж бараа материалын зардлыг 60,115.9 мянган төгрөг, норматив зардлыг 5,417.9 мянган төгрөг, эд хогшил худалдан авах зардлыг 815,721.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 13,940.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын

талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус эмнэлэг нь шилэн дансны төлөвлөгөөг гаргаж эмнэлгийн захирлаар батлуулан хуулийн хугацаанд ил тод байршуулсан байна.

Шилэн дансны цахим хуудсанд сар бүр оруулах 48, хагас жилд оруулах 4, жил тутам оруулах 11, тухай бүр оруулах 120 мэдээлэл буюу нийт 183 мэдээлэл оруулахаас 180 мэдээллийг хуулийн хугацаанд баталгаажуулан мэдээлж байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн Улсын гуравдугаар төв эмнэлгийн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, худалдан авах ажиллагаа, үндсэн хөрөнгө, бараа материалын данстын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Завсрын аудитаар 516,769.7 мянган төгрөгийн 5 зөвлөмж өгснөөс жилийн эцсийн аудитаар дахин үнэлэхэд бүрэн хэрэгжүүлсэн байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 15,848.5 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгснөөс, 15,848.5 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 1 зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, биелэлт 80.0 хувьтай байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	15,848.5	2	15,848.5	80.0
Нийт дүн	3	15,848.5	2	15,848.5	80.0

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын чанарын болон төлбөрийн хяналтаар дотоод хяналт хангалтгүйгээс санхүүжилт хасагдсан 1 зөвлөмж хэрэгжээгүй, зөрчил давтагдсан тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-г бүрэн хэрэгжүүлж байгааг шалгах.
2. Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдад олгох ур чадварын нэмэгдлийн шалгуур үзүүлэлтийг батлаагүй байгаа нь салбарын хувьд жигд бус байна.
3. Улсын Гуравдугаар төв эмнэлгийн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлуулах саналыг Эрүүл мэндийн яаманд хүргүүлж, батлуулсан эсэхийг шалгах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 20,513,340.5 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 20,513,340.5 мянган төгрөгийн 2 алдааг залрууллаа. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн хасагдсан хөрөнгийн дүнг 15,697,722.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.
- Хөрөнгийн хөдөлгөөнийг дутуу бүртгэсний улмаас 4,815,618.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг санхүүгийн тайланд зөрүүтэй тусган тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална. 5.1.4-д “үнэн зөв байх”, 5.1.5-д “хэмжигдэхүйц байх” гэж заасантай нийцээгүй, УСНББОУС 1-ийн 27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой”, санхүүгийн тайлагналын “Иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 349,411.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 3,207.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 346,203.9 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 349,411.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 542,656.7 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

5.1 Төлбөрийн акт

Түрээслэгч 2 байгууллагатай түрээсийн гэрээг байгуулахдаа талбайн хэмжээг 12м² аар дутуу хэмжилт хийснээс 3,207.6 мянган төгрөгийн түрээсийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д "Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна. Уг төлбөр тухайн эд хөрөнгийг худалдан авах үнийн төлбөрт үл хамаарна", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн баталсан "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай", 49 дүгээр тогтоолын 49.1-т "Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг түрээслүүлэх төлбөрийн доод хязгаарыг түрээслэгчийн эрхэлж буй үйл ажиллагааны ангилал, салбарын чиглэл зэргийг харгалзан дараах байдлаар тогтооно" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт дутуу төвлөрүүлсэн 3,207.6 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Албан шаардлага

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын чанарын хяналтаар тус эмнэлгийн бүрдүүлэлтэд тавих хяналт хангалтгүйгээс Эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжилсэн 72,865,046.3 мянган төгрөгийн гүйцэтгэлийн санхүүжилтээс цахим болон эмчийн хяналтаар 346,203.9 мянган төгрөгийн санхүүжилт хасагдсан, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д "даатгуулагчид үзүүлсэн энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх", 13.1.2-т "эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангах", 13.1.4-т "даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэр, төрөл, хэлбэр, тоо хэмжээ, зардал болон бусад мэдээллийг бүртгэх, хадгалах, эрүүл мэндийн даатгалын байгууллагад мэдээлэх", 13.1-д "эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний баримтын бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах, ЭМДС-ын эмчийн хяналтаар хасагддаг зөрчлийг 30.0 хувь хүртэл бууруулж, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Жилийн эцсийн тооллогын тайлан буюу илтгэх хуудсыг бэлтгэхдээ бараа материалын тооллогыг санхүүгийн тайлангийн бараа материалын тодруулгын дагуу ангилан, нэгтгэж, баталгаажуулаагүй, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална. 5.1.4-д "үнэн зөв байх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тооллогын тайлан буюу илтгэх хуудсанд бараа материалыг ангиллын дагуу нэгтгэж байх, дотоод хяналтыг сайжруулах.

2. Худалдан авах ажиллагааны хуультай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тендер шалгаруулалтын баримт бичиг боловсруулж батлахдаа оролцогчийн ерөнхий шаардлагад "Хүүхэд хамгааллын бодлого" баталж ирүүлэхийг, шалгалт туршилт хэсэгтээ оролцогчдыг уг ажиллагаанд оролцох боломжийг тусгаагүй байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.10-т "Хүүхэд хамгааллын тухай хуулийн 30.4-т заасан хүүхэд хамгааллын бодлого батлаагүй хуулийн этгээд", 13 дугаар зүйлийн 13.2-т "Захиалагч шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 13.1-д заасан шалгалт, туршилтыг өөрөө зохион байгуулж болно", 13.3-т "Энэ хуулийн 13.2-т заасан шалгалт, туршилтыг хэрхэн зохион байгуулах тухай тендер шалгаруулалтын баримт бичигт зааж, оролцогчийг уг ажиллагаанд оролцох боломжоор хангана", гэсэн заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хуулийн заалтыг хэрэгжүүлэн, тендер шалгаруулалтын зааварчилгаандаа зохих заалтыг тусгах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн дүнг зөрүүтэй тодруулсан.	1	15,697,722.2			1	15,697,722.2	1	15,697,722.2				
2	Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн үлдэгдлийг зөрүүтэй тусган тайлагнасан.	1	4,815,618.3	1	4,815,618.3			1	4,815,618.3				
	Дүн	2	20,513,340.5	1	4,815,618.3	1	15,697,722.2	2	20,513,340.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Түрээслэгч 2 байгууллагатай ашиглалтын гэрээг байгуулахдаа талбайн хэмжээг 12м ² аар дутуу хэмжилт хийснээс 3,207.6 мянган төгрөгийн түрээсийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн байна	1	3,207.6	1	3,207.6								
2	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын чанарын хяналтаар тус эмнэлгийн бүрдүүлэлтэд тавих хяналт хангалтгүйгээс Эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжилсэн 72,865,046.3 мянган төгрөгийн гүйцэтгэлийн санхүүжилтээс цахим болон эмчийн хяналтаар 346,203.9 мянган төгрөгийн	1	346,203.9			1	346,203.9						

П.Н.Шастины Улсын гуравдугаар төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан

	санхүүжилт хасагдсан байна.												
3	Бараа материалын тооллогыг санхүүгийн тайлангийн бараа материалын тодруулгын дагуу ангилан, нэгтгэж, баталгаажуулаагүй, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна	1						1					
4	Тендер шалгаруулалт-ын баримт бичиг боловсруулж батлахдаа "Хүүхэд хамгааллын бодлого" баталж ирүүлэхийг, шалгалт туршилт хэсэгтээ оролцогчдыг уг ажиллагаанд оролцох боломжоор хангах гэсэн заалтыг тусгаагүй байна	1						1					
	Дүн	4	349,411.5	1	3,207.6	1	346,203.9	2					



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 39/A0150185

Улаанбаатар хот

САГ-2026/314/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын гуравдугаар төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус төв нь түрээслэгч 2 байгууллагатай ашиглалтын гэрээ байгуулахдаа талбайн хэмжээг 12 м²-аар дутуу хэмжилт хийснээс нийт 3,207,600.00 /гурван сая хоёр зуун долоон мянга зургаан зуун/ төгрөгийн түрээсийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д "Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна. Уг төлбөр тухайн эд хөрөнгийг худалдан авах үнийн төлбөрт үл хамаарна", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3 "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.2 "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлсэн, ашиглуулсны төлбөр болон борлуулсны орлогыг дутуу төвлөрүүлсэн, эсхүл төвлөрүүлээгүй" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь**:

1. Дутуу тооцсон талбайн түрээсийн 3,207,600.00 /гурван сая хоёр зуун долоон мянга зургаан зуун/ төгрөгийг Улсын гуравдугаар төв эмнэлгийн захирал Ц.Төмөр-Очиоор нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Төлбөрийн актын биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Улсын гуравдугаар төв эмнэлгийн захирал /Ц.Төмөр-Очир/, Санхүү, бүртгэлийн албаны дарга /М.Энхчимэг/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Ч.ЭРДЭНЭЖАВ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 243/A0150185

Улаанбаатар хот

САГ - 2026/314/НА - СТА - ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Гуравдугаар төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус төвийн эрүүл мэндийн даатгал хариуцсан ажилтнуудын баримтын бүрдүүлэлтэд тавих хяналт хангалтгүйгээс Эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжилсэн гүйцэтгэлийн санхүүжилтээс цахим болон эмчийн хяналтаар 346,203,902.00 /гурван зуун дөчин зургаан сая хоёр зуун гурван мянга есөн зуун хоёр/ төгрөгийн санхүүжилт хасагдсан байна.

Энэ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д "даатгуулагчид үзүүлсэн энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх", 13.1.2-т "эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангах", 13.1.4-т "даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэр, төрөл, хэлбэр, тоо хэмжээ, зардал болон бусад мэдээллийг бүртгэх, хадгалах, эрүүл мэндийн даатгалын байгууллагад мэдээлэх", 13.1- "эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлж, дотоод хяналтыг сайжруулж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг 20.0 хувь хүртэл бууруулж, үр дүнг үнэлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын гуравдугаар төв эмнэлгийн захирал /Ц.Төмөр-Очир/, Санхүү, бүртгэлийн албаны дарга /М.Энхчимэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Ч.ЭРДЭНЭЖАВ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264280

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-39.Docx